ЧИХРИЙН ШИЖИН ХЭВ ШИНЖ 2-ТОЙ АХМАД НАСТАНД ГЛЮКОЗЖСОН ГЕМОГЛОБИНЫ ХЭМЖЭЭ БОЛОН ХҮНДРЭЛИЙН БАЙДЛЫГ СУДАЛСАН НЬ

А. Чинчулуун[1], А.Аюурзана[2], Б. Батхүү[2]

[1]АШУҮИС, ӨАУТ-ийн өрхийн резидент
[2]АШУҮИС-ийн АУС-ийн ӨАУ-ны тэнхмийн багш

Түлхүүр үг:
Ахмад настны чихрийн шижин хэв шинж 2, глюкожсон гемоглобин, жижиг судасны хүндрэл, том судасны хүндрэл

Товч утга: Ахмад настанд тохиолдох чихрийн шижин хэв шинж 2 нь глюкозийн өөрийн хяналтаас маш их шалтгаалж байна. Учир нь манай улсад уг өвчний хүндрэлийн шалтгаалсан эмгэгүүдийн тоо ихсэж байгаа бөгөөд улмаар хөгжлийн бэрхшээл үүсэх тохиолдол мөн адил ихэссэн тоо баримт байна. Бид судалгаандаа уг өвчний оношоор эмчлүүлж буй 50 ахмад настныг хамруулж улмаар эдгээрийн глюкожсон гемоглобины түвшин, улмаар ойрын болон алсын бай эрхтний хүндрэл өгсөн эсэхийг судлалаа. Оролцогчдыг инсулин тарилгаар хийлгэдэг болон эмийн эмчилгээний бүлэг гэж 2 бүлэг болгон ангилсан бөгөөд инсулин эмчилгээний бүлгийн оролцогчдод жижиг судасны хүндрэл их, мөн том судасны хүндрэл тохиолдож байлаа. Хоёр бүлэгт артерийн даралт ихсэх өвчин хавсарч илэрч байгаа зүй тогтол ажиглагдлаа.

Үндэслэл: Ахмад настаны бие махбодид гарах өөрчлөлттэй холбоотой цусны даралт ихсэх өвчин, зүрхний титэм судасны өвчин, тархинд цус харвах, чихрийн шижин, хавдар, амьсгалын замын архаг өвчин, нүдний болор цайх болон даралт ихсэх, сонсгол муудах, хөдөлгөөн алдагдах, сэтгэцийн хямралтай болох, шүд, амны хөндийн эмгэг, гэмтэл, бэртэл зэрэг олон өвчин тохиолдож тэдгээр нь архаг удаан явцтай байдгаараа онцлог ба чихрийн шижингийн хяналт хангалтгүй явагдсанаас олон эрхтний хүндрэлд хүргэж эрүүл мэндийн зардал жил тутам нэмэгдэж байна[1-7]. Мөн артерийн гипертензи болон чихрийн шижин хавсарсан үед тархинд цус харвах, титэм судасны эмгэг, зогсонгишлын зүрхний дутагдал, захын судасны эмгэг, зүрх судасны өвчин, бөөрний эмэгүүд бий болох эрсдэл эрс нэмэгддэг[8,9].

Зорилго: Ахмад настанд тохиолдох чихрийн шижин хэв шинж 2 -ын хүндрэлийн байдлыг судлах

Зорилт:

1. Судалгаанд оролцогсдыг түүвэрлэн бүлэг болгон ангилж глюкожсон гемоглобины түвшинг тогтоох
2. Судалгаанд оролцож буй 2 бүлэгт тохиолдох бай эрхтний хүндрэлийг тогтоох

Судалгааны материал ба арга зүй: Энэхүү судалгааг аналитик судалгааны түүвэр судалгааны аргаар хийсэн. Судалгаанд Баянзүрх, Хан-Уул дүүргийн дотоод шүүрлийн эмчийн хяналтанд буй эмэгтэй 55-с дээш эрэгтэй 60-с дээш насны төлбөрийг төрөөс хариуцах эмийн хөнгөлөлтөд хамрагдаж буй чихрийн шижин хэв шинж 2-той 50 ахмадыг санамсаргүй түүврийн аргаар хамруулан эмийн эмчилгээ болон инсулин эмчилгээнд хамрагдсан байдлаар нь 2 бүлэг болгон харьцуулж глюкозжсон гемоглобины хэмжээ, хүндрэлийн байдлыг түүвэрлэн шүүж мэдээллийг SPSS болон EXCEL программуудыг ашиглан статистик боловсруулалтыг хийлээ.

Үр дүн: Судалгаанд дунджаар 66 насны 28 эрэгтэй (56%), 22 эмэгтэй (44%) хамрагдав. Глюкозжсон гемоглобины хэмжээний хувьд инсулин эмчилгээтэй бүлгийн дундаж 12 % бол эмийн эмчилгээтэй бүлгийнх 8,6% байна. Инсулин эмчилгээнд хамрагдаж буй бүлгийн 92%-д эмийн эмчилгээ хийлгэж буй бүлгийн 32%-д нь жижиг судасны хүндрэл илэрсэн бол том судасны хүндрэлийн хувьд зөвхөн инсулин эмчилгээтэй бүлгийн 12%-д илэрсэн. Захын мэдрэлийн эмгэг хамгийн элбэг буюу 26%-д хөл ирвэгнэх, бадайрах, өвдөх, мэдрэхүй буурах хүндрэл илэрчээ. Нийт судалгаанд хамрагдагсадын 78% нь артерийн гипертензи хавсарсан байна (P утга >0.05) .

Хэлцэмж: Судалгаанд оролцогсдын глюкожсон гемоглобины түвшин өндөр байгаа бусад хөгжиж буй улс орнуудад хийгдсэн судалгааны ажлын үр дүнтэй дүйж байна [10]. Харин чихрийн шижин хэв шинж 2-ийн хүндрэлээрээ бусад оронтой харьцуулахад дунджаас доош түвшинд байна[11].

Дүгнэлт:

1. Судалгаанд хамрагдсан оролцогсдын цусан дахь глюкозжсон гемоглобины хэмжээ өндөр байгаа нь эмчилгээний үр дүн болон цусны глюкозын өөрийн хяналт муу байгааг харуулж байна.

2. Глюкозжсон гемоглобины хэмжээ өндөр байгаатай холбоотойгоор чихрийн шижингийн хүндрэл их байна.
3. Артерийн гипертензи болон чихрийн шижин судалгаанд хамрагдсан ихэнх оролцогчдод хавсарсан байгаа нь тархинд цус харвах, титэм судасны эмгэг, захын судасны эмгэг, зүрх судасны өвчин, бөөрний эмгэгүүд бий болох эрсдэлийг эрс нэмэгдүүлж байна.

Талархал: Энэхүү судалгааг хийхэд туслалцаа үзүүлсэн Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвийн дотоод шүүрлийн их эмч Б.Гэрэлмаа болон Хан-Уул дүүргийн дотоод шүүрлийн их эмч н.Болормаа болон судалгаанд оролцсон нийт үйлчлүүлэгч нартаа эрүүл энхийг хүсч талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *https://www.legalinfo.mn/annex/showPrint/1514*
2. *https://www.mohs.mn/uploads/files/e5abf79708ddc9476f5cc6b151ef4aa9.pdf*
3. *Эмнэлзүйн анагаах ухааны монголын сэтгүүл*
4. *Эмнэлзүйн удирдамж. Артерийн гипертензи*
5. *Эмнэлзүйн удирдамж. Чихрийн шижин хэв шинж 2*
6. *Артерийн гипертензийн менежментийг бэхжүүлэх сургалтын гарын авлага.*
7. *Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалт . Монгол улс,2013 үндэсний гуравдугаар судалгаа.*
8. *Briatore L, Salani B, Andraghetti G, Danovaro C, Sferrazzo E, Scopinaro N, Adami GF, Maggi D, Cordera R. Restoration of acute insulin response in T2DM subjects 1 month after biliopancreatic diversion. Obesity (Silver Spring). 2008;16(1):77–81.*
9. *Qaseem A, Wilt TJ, Kansagara D, Horwitch C, Barry MJ, Forciea MA, Clinical Guidelines Committee of the American College of Physicians. Hemoglobin A1c targets for glycemic control with pharmacologic therapy for non pregnant adults with type 2 diabetes mellitus: a guidance statement update from the American College of Physicians. Ann Intern Med. 2018;168:569–76.*
10. *Pirart J, Lauvaux JP, Rey W. Blood sugar and diabetic complications. N Engl J Med. 1978;298(20):1149.*
11. *Holman RR, Paul SK, Bethel MA, Matthews DR, Neil HA. 10-year follow-up of intensive glucose control in type 2 diabetes. N Engl J Med. 2008;359:1577–89.*

STUDY OF GLUCOSED HEMOGLOBIN MEASURES AND COMPLICATIONS IN THE ELDERLY TYPES OF DIABETES II

A.Chinchuluun[1], A.Ayurzana[2], B.Batkhuu[2]

[1]resident student of dept.of Family Medicine, MNUMS
[2]Lecturer at the department of Family Medicine, MNUMS

Type 2 diabetes in the elderly is highly dependent on self-glucose control. This is because the number of diseases caused by the disease is increasing in our country, and the number of people with disabilities is also increasing. We have studied 50 elder patients who were diagnosed with the disease and examined their glucose hemoglobin levels, as well as their proximal and distant target complications. Participants were divided into two groups: insulin injections and drug therapy groups, and participants in the insulin treatment group had high vascular complications, hence the large vascular complications. In both groups, the incidence of hypertension was high.